



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 241

Улаанбаатар хот

Г Хорооны 2011 оны 130 дугаар тогтоолд Г
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.6 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 130 дугаар тогтоолын 9 дэх заалтыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

“9. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай:

1/ Үнэт цаас худалдсаны орлого буюу үнэт цаас гаргагч “Силикат” ХК-ийн дансанд байршсан мөнгөн хөрөнгийн андеррайтерээс бусад иргэн, хуулийн этгээдээс оруулсан хөрөнгийг 2011 оны 8 дугаар сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд тусгаарлах;

2/ Энэ тогтоолын 9.2-д заасан хугацаанаас хойш үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулгад тусгагдсан бусдад төлөх өр болох 1,436,210,000 /Нэг тэрбум дөрвөн зуун гучин зургаан сая хоёр зуун арван мянга/ төгрөгийг төлбөр хүлээн авагчид нь шилжүүлж, үлдсэн мөнгөн хөрөнгийг тус хувьцаат компанийн Төрийн банк дах дансанд байршуулах;

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 130 дугаар тогтоолд дараах агуулга бүхий 11 дэх заалтыг нэмсүгэй:

1.“11 “Силикат” ХК-ийн Төрийн банк дах хадгаламжийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгөөс хувь нийлүүлэгчдийнхээ хурлыг шинэчилсэн бүрэлдэхүүнтэйгээр зарлан хуралдуулж, төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг захиран зарцуулах талаар холбогдох шийдвэрийг гаргаж тус Хороонд ирүүлэх хүртэлх хугацаанд зарлагын гүйлгээ хийхгүй байхыг “Силикат” ХК /Ц.Содгэрэл/-д анхааруулсугай.”

3. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, “ҮЦТТТХТ” ХХК-д мэдэгдэхийг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН